



Англи хэл суралцагчдад зориулан Арлингтоны улсын сургуулиас явуулж буй хөтөлбөрт  
хийсэн үнэлгээний тайлан

НЭГДСЭН ТАЙЛАН  
2012 оны 09 сарын 18

Barbara D. Acosta, Эрдэм Шинжилгээний ахлах ажилтан  
Lottie Marzucco, Ахлах Эрдэм шинжилгээний ажилтан  
Christiane Connors, Туслах эрдэм шинжилгээний ажилтан  
Charlene Rivera, Ахлах байцаагч, Гүйцэтгэх захирал

“The George Washington “ Их Сургуулийн “Equity and Excellence in Education” Төв

“The George Washington “ Их Сургуулийн “Equity and Excellence in Education” (Цаашид “GW-CEEE” гэж товчлох. Орч )Төвийн үндсэн зорилт нь боловсролын шинэтгэлийг өргөжүүлж сурагчдын сурлагын өндөр стандартыг хангах явдал билээ.

“GW-CEEE” байгууллага нь сургалтын хөтөлбөр төлөвлөлт, хэрэгжүүлэлтийн талаар бодлого аргачлал бололвсруулж, судалгааны ажил явуулдаг ба мужуудын боловсролын байгууллагууд, сургуулиуд, сан болон холбооны байгууллагуудад зориулан мэргэжил дээшлүүлэх болон техникийн зөвлөгөө өгөх үйлчилгээг эрхэлдэг юм.

“GW-CEEE” Байгууллага

*“The George Washington “ Их Сургуулийн “Equity and Excellence in Education” Төв*

[www.ceee.gwu.edu](http://www.ceee.gwu.edu)

800-925-3223

*Энэ хуудсыг зориуд хоосон үлдээсэн болно.*

## Талархал

---

Энэхүү үнэлгээг явуулахад үнэ цэнэтэй мэдээллээр хангаж ажилласан Арлингтоны Улсын сургууль (*Цаашид “**APS**” гэж товчлох*) - ийн ажилтан ажилчдад талархал илэрхийлье. Ноен Патрик Мурфи, APS-ийн УЗ-ын гишүүд болон ESOL/HILT (*Англиас өөр хэлээр яригчдад зориулсан Англи хэлний хөтөлбөр/ Хэлний Эрчимжүүлсэн Сургалт. Цаашид “**ESOL/HILT**” гэж товчлох. Орч*) Албаны Эцэг эхчүүдийн зөвлөлөөс бидний ажилд дэмжлэг үзүүлж ажиллалаа. Англи хэл суралцагч (*цаашид “**ELL**” гэж товчлох*)-дийг дэмжих бүлэгт орж ажиллан эхний үнэлгээний ажилд гар сэтгэл гаргаж ажилласан тасаг хэлтсүүд, сургуулиудын удирдлага, багш нар, эцэг эхчүүд болон гэр бүлд туслах (хос хэлтэй) ажилчдад гүн талархал илэрхийлж байна.

Мөн үнэлгээний багийн ажилчдыг сургууль, ангидаа урьж, ярилцлага, санал асуулгад оролцсон сургуулийн захирлууд, багш нар, гэр бүлд туслах мэдээллийн ажилчид, HILT хөтөлбөрийн зөвлөх багш, арга зүйч багш нарт чин сэтгэлээсээ талархаж байгааг хүлээн авна уу? Мөн судалгааны зорилготой бүлэгт орж ажилласан эцэг эх, хэлмэрч нарт баярлалаа!

Хөтөлбөрийн төлөвлөлт, мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх болон бусад судалгаатай холбогдох ажилд цаг хугацаа зарцуулан хүчин зүтгэсэн судалгааны багын нэр дурьдсан хамт олонд талархал илэрхийлье.

- Lisa Stengle, Судалгааны багийн туслах захирал
- Regina Van Horne, Судалгааны мэргэжилтэн
- Faith Tabatabai, ESOL/HILT Албаны дарга
- Dan Hauser, ESOL/HILT албаны мэдээллийн сангийн мэргэжилтэн
- Robin Liten-Tejada, Дунд сургуулийн ESOL/HILT хөтөлбөрийн мэргэжилтэн
- Nancy Belcher, Бага сургуулийн ESOL/HILT хөтөлбөрийн мэргэжилтэн
- Francesca Reilly-McDonnell, ESOL/HILT –ийн тусгай төслийн мэргэжилтэн
- Amy Ramirez, Захиргааны туслах ажилтан

Бидний ажилд гар бие оролцсон APS-ийн ажилтан, албан хаагчид болох дараах хүмүүс бидний талархлыг хүлээн авна уу. Үүнд: Margaret Gilhooley- Заах арга зүйн хэлтсийн туслах захирал; Salah Khelfaoui- мэдээллийн үйлчилгээний захирал ; Paula Lamina- Англи хэлний сургалтын Албаны дарга; Margaret Chung- Математикийн сургалтын Албаны дарга; Michelle Picard- Цэцэрлэгээс өмнөх болон бага боловсролын газрын захирал; Jennifer Powell- Шинжлэх Ухааны хичээлийн HILT сургалтын мэргэжилтэн; Mariola Aguilar -Математикийн HILT сургалтын мэргэжилтэн; Linda Smith- Бага ангийн ESOL/HILT хөтөлбөрийн мэргэжилтэн; Suzanne Swindeman- сургууль завсардалтаас сэргийлэх мэргэжилтэн; Paul Velit, Jemica Jones, болон Raj dusumilli - “Enterprise Solutions” компани болон Marsha Mottesheard, Audrey Chan and Cindy Warkentin, ESOL/HILT Албаны Захиргааны алба.

Эцэст нь мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх болон судалгааны ажлын бэлтгэл ажлыг гардаж ажилласан “GW-CEEE”-ийн дараах албан хаагчдад талархал илэрхийлж буйг хүлээн авна уу. Breana Bayraktar, Charlotte Blane, Janet Brown, Jennifer McCreadie, Marilyn Muirhead, Marjorie Rosenberg, Ryan Tyler, Roshaun Tyson.

## Судалгааны ажлын ерөнхий тайлан

Энэхүү судалгааны ажлын гол зорилго нь APS-ийн УЗ, Гүйцэтгэх захирал (Superintendent), ESOL/HILT Албаны удирдлага болон Англи хэл суралцагчдад зориулсан сургалт үйлчилгээтэй холбоотой шийдвэр гаргах түвшний хүмүүсийн хэрэгцээнд нийцэхүйц, сургалтын хөтөлбөрийн олон талт цогц үнэлгээ явуулахад оршиж байв.

“The George Washington University Center for Equity and Excellence in Education (цаашид “GW-CEEE” гэж товчлох. Орч) байгууллагаас Англи хэл суралцагчдад зориулсан хөтөлбөрт хамрагдаж буй сурагчдад хамаарал бүхий дараах 5 сэдвийг сонгож ажилласан болно. Эдгээрт: Хөтөлбөрөөс гарах шалгуур үзүүлэлтийг хангах хүртэлх хугацаа, Англи хэл суралцагч ангилалд байх хугацаа; Математик, Унших бичгийн хичээлийн Улсын шалгалтад үзүүлж буй амжилтын зөрүүг арилгах, Ахисан түвшний хөтөлбөрт элсэн орж буй болон төгсөн гарц буй үзүүлэлт, ахлах сургууль төсгөлтийн хувь зэрэг болно.

Үүний зэрэгцээ үнэлгээний баг APS-ийн бодлого, үйл ажиллагаа, сургалтын аргачлал нь Англи хэл суралцагчид, а) англи хэлний мэдлэгийн түвшингээ ахиулах, б) хөтөлбөрөөс гарч, энгийн тэнхимийн сургалтад хамрагдах явцад хэрхэн, ямар хэмжээнд нөлөөлж байгаа талаар судалгаа хийсэн болно.

Сурагчдын сурлагын үр дүнгийн талаархи мэдээллийг Төлөвлөлт, Үнэлгээ, ESOL/HILT Албанаас бэлдэж ирүүлсэн байна. Үүний зэрэгцээ GW-GEEE-ийн үнэлгээчид мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийхдээ “Promoting Excellence Appraisal System” буюу (PEAS) аргачлалд багтдаг дараах 7 чиглэлээр төвлөрч ажилласан юм. Үүнд: Сургалтын Хөтөлбөрийн төлөвлөлт, Сургалтын Хөтөлбөрийн Хэрэгжилт, Манлайлал, Боловсон хүчин, Мэргэжил дээшлүүлэлт, Үнэлгээ & хариуцлагын тогтолцоо, эцэг эх/ олон нийтийн харилцаа зэрэг болно. Эдгээр мэдээллийг цуглуулахдаа төрөл бүрийн сонирхол, бүлэг, төлөөллийг оролцуулсан ба үүнд APS –ийн тодорхой тасаг, хэлтсүүд, сургуулиудын удирдлага, ESOL/HILT хөтөлбөрийн багш нар, ерөнхий эрдмийн багш нар, гэр бүлүүдэд туслах мэдээллийн ажилчид, HILT хөтөлбөрийн мэдээллийн зөвлөхүүд, гэр бүлүүд болон сурагчид багтаж байгаа юм. Судалгааны үр дүнд үндэслэж, GW-GEEE байгууллагаас тодорхой зөвлөмж гаргаж байгаа ба энэ нь ELL сурагчдад үзүүлж буй сургалт үйлчилгээний зохион байгуулалт, удирдлага, үйл ажиллагааны чанарыг сайжруулахад чиглэгдэж байгаа билээ.

Хүснэгт 1-д сурагчдын сурлагын үр дүнтэй холбогдох, мөн PEAS аргачлалын 7 чиглэл тус бүрээр шаардлага хангаж буй болон цаашид анхаарч сайжруулах шаардлагатай арга хэмжээнүүдийн талаар дүгнэлтийг оруулав.

Хүснэгт 1. Шаардлага хангаж буй болон цаашид анхаарах чиглэлүүд

PEAS –ийн чиглэлүүд	Давуу талууд	Анхаарах зүйлс
<b>Сурагчдын сурлагын үр дүн</b>	<ul style="list-style-type: none"><li>Унших болон математикийн хичээлд ихэнхи ELL болон ELL ангилалд багтаж байсан сурагчдын сурлагын амжилтын ялгаа багасч байна.</li><li>APS-ийн дунд сургуульд эхэлж орсон ELL сурагчид хэлний ахисан түвшинд хүрмэгц гүнзгийрүүлсэн</li></ul>	<ul style="list-style-type: none"><li>Дунд сургуулийн сурагчдын тэн хагас нь зургаагаас дээш жилийн турш LEP ангилалд багтаж байна</li><li>2008 оны байдлаар Англи хэлний мэдлэгийн 3-р түвшинд байсан дунд сургуулийн сурагчид унших, математикийн хичээлд үзүүлэх</li></ul>

	<p>сургалтад хамрагдаж буй үзүүлэлт нь ELL үйлчилгээнд хамрагдаж байгаагүй сурагчдаас өндөр байгаа юм.</p>	<p>амжилт зогсонги байдалд буй</p> <ul style="list-style-type: none"> <li>• APS-ийн бага ангид элсэн орсон ELL сурагчид дунд сургуульд орсон дараа гүнзгий шатны сургалтад хамрагдах байдал цөөрсөн</li> <li>• APS –д сурч байгаа, LEP статуст хамрагдаж байгаагүй сурагчдын ахлах сургууль төгсөх үзүүлэлт LEP ангилалд багтаж байсан сурагчдаас өндөр байгаа</li> </ul>
<p><b>Сургалтын хөтөлбөр төлөвлөлт</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>• ELL сурагчдад үзүүлэх боловсролын үйлчилгээ судалгаанд түшиглэсэн</li> <li>• ESOL/HILT Албанаас хэлний хичээлийг хичээлийн агуулгатай хослуулж, WIDA болон SOL стандартыг хангахуйц өндөр чанарын арга зүйн зөвлөмж чиглэл гаргаж ажиллаж байна.</li> <li>• APS-аас Испани болон бусад хэлээр яригч сурагчдын анги завсардалтын тоог бууруулахад тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлж буй</li> </ul>	<p>ESOL/HILT Албанаас үзүүлж буй үйлчилгээнүүд APS-ийн сургуулиуд болон ангиудын түвшинд адил тэгш байх зарчим тэр бүр хангагдахгүй байна.</p>
<p><b>Заах арга зүйн хэрэгжүүлэлт</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>• ELL сурагчдад үйлчилгээ үзүүлж буй багш нар заах арга зүйн чанарын хэд хэдэн шалгуураар харьцангуй өндөр үнэлгээ авсан.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Зааж буй хичээлийн агуулга сурагч бүрт ойлгомжтой байх шалгуурыг ELL сурагчидтай ажиллаж буй багш нар тэр бүр тэгш хангаж чадахгүй байгаа</li> <li>• Англи хэлний сургалт нь хичээлийн агуулгатай авцалдахгүй байгаагаас ELL сурагчид ангийн түвшинд хүрсэн мэдлэг авч чадахгүй байгаа</li> <li>• Бага сургуулийн унших хичээл ELL сурагчдын хэрэгцээнд тэр бүр нийцэхгүй байгаа</li> <li>• APS-аас танхимын сургалтын бодит туршлагыг бусад багш нарт хүргэх бодит стратеги</li> </ul>

<b>Манлайлал</b>	<ul style="list-style-type: none"> <li>• APS-аас баримталж буй бодлого, чиглэл, зорилтуудын утга агуулга сайтай, ELL сурагчдын сурлагын амжилтыг ахиулахад нөлөөлж буй</li> <li>• Захиргаа, тасаг албадуудад ажиллаж буй ажилтан, албан хаагчид ELL сурагчдын сургалтад үүрэг хүлээж ажиллаж чаддаг</li> <li>• Багш нар, эцэг эхчүүд болон сурагчдын үнэлгээгээр ихэнхи сургуулиуд олон үндэстэний ашиг сонирхлыг сайн төлөөлж чаддаг</li> </ul>	<p>байхгүй байгаа</p> <ul style="list-style-type: none"> <li>• ELL сурагчдыг сургах ажил тэр бүр бүх сургуулийн хэмжээнд төвлөрч, зүгширч, нэг чиглэлд орж төлөвшөөгүй</li> </ul>
<b>Боловсон хүчин</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Багш, сургагч нараас гадна тасаг хэлтсүүдэд ELL сурагчид, тэдний гэр бүлийг дэмжих хэд хэдэн чухал албан тушаал гаргасан байна.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Сургуулиудад бүх ELL бүлгийн сурагчдын хэрэгцээг хангахуйц сургагч багш нарын хүрэлцээ хангалтгүй</li> <li>• ELL сурагчдад багшилж байгаа зарим үндсэн багш нар сурагчдын хэрэлт хэрэгцээг хангахуйц туршлага ур чадвар дутаж байгаа</li> <li>• ESOL/HILT хөтөлбөрийн зарим багш нар өөрсдийн зааж буй хичээлийн агуулгатай уялдах туршлага мэдлэг дутаж байгаа</li> </ul>
<b>Мэргэжил дээшлүүлэх</b>	<ul style="list-style-type: none"> <li>• APS-аас ELL сурагчдад чанартай сургалт явуулж чадахуйц багш сургагч бэлдэх талаар зарим ахиц гарч буй</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Тасаг хэлтсүүдэд ELL сурагчдад зориулсан сургалтын шинэчлэлт, өөрчлөлтүүд бүрэн хэрэгжиж байгааг хянах системтэй арга хэрэгсэл байхгүй</li> </ul>
<b>Үнэлгээ &amp; Хариуцлага</b>	<ul style="list-style-type: none"> <li>• APS –аас ELL сурагчиддаа чиглэсэн сургалт хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэх тогтолцоог нэвтрүүлж буй</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Тасаг хэлтсүүд нь сургуулийн удирдлагын зүгээс ELL сурагчдад үзүүлж буй сургалт үйлчилгээний чанарт хариуцлага хүлээдэг болгох үр дүнтэй</li> </ul>

		<p>тогтолцоог нэвтрүүлж хараахан чадаагүй</p> <ul style="list-style-type: none"> <li>• Одоогийн ашиглагдаж байгаа мэдээллийн сан нь ELL сурагчдын сурлагын явцыг хянах хэрэгсэл болж чадаагүй</li> </ul>
<p><b>Эцэг эх, олон нийтийн хамтын ажиллагаа</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>• APS-аас ELL сурагчдын ар гэр, олон нийттэй харилцах арга замыг хөгжүүлж чадсан</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Нийт эцэг эхчүүд сурч боловсрох, дэмжлэг авах нөөц боломжийн талаар хангалттай мэдээлэл авч чадахгүй байгаа</li> </ul>



## **Зөвлөмж**

---

Энэхүү судалгааны үр дүнгээс үзвэл дараах дөрвөн чиглэлд илүү анхаарч шинэчлэл хийх шаардлагатай байна. Үүнд: а) *ELL сурагчдад чиглэсэн сургалт үйлчилгээний чанарт тухайн сургуулийн хэмжээнд хариуцлага хүлээх байдлыг дэмжих*, б) *Нийт ELL сурагчдын эрэлт хэрэгцээ тэгш хангагдаж байх нөхцлийг хангах үүднээс хөтөлбөрийн арга хэлбэрийг сайжруулах*, в) *ELL сурагчдад багшилж байгаа багш нарын ажлын байранд түшиглэсэн, байнгын мэргэжил дээшлүүлэх байдлыг хэлбэршүүлэх*, г) *ELL сурагчидтай холбогдож гарч буй сургалтын болон үйл ажиллагааны холбогдолтой шийдвэр журмын чанарт нөлөөлөхүйц бодит мэдээллийн сангийн найдвартай үйл ажиллагааг нэмэгдүүлэх*. Судалгаанаас гаргаж буй зөвлөмжүүд нь дээр дурьдсан “PEAS” хэмжүүрийн хүрээнд дурьдагдсан цаашид анхаарвал зохих чиглэлүүдийг шийдвэрлэхэд чиглэгдэж байгаа юм. Эдгээрийг дараах жагсаалтад товч дурьдсан ба дэлгэрэнгүйг энэхүү тайлангийн Зөвлөмж хэсэгт багтаасан буй.

*ELL сурагчдад чиглэсэн сургалт үйлчилгээний чанарт тухайн сургуулийн хэмжээнд хариуцлага хүлээх байдлыг дэмжих,*

- (1) Сургуулийн удирдлагаын зүгээс ELL сурагчдад үзүүлж буй сургалт үйлчилгээний чанарт хариуцлага хүлээдэг болох
- (2) Сургууль тус бүрийн явуулж буй үйл ажиллагааг тухайн сургуулийн ELL сурагчдын өвөрмөц онцлогт тохируулж загварчлах
- (3) ESOL/HILT/HILTEX хөтөлбөрийн багш нарыг ерөнхий эрдмийн багш нартай хамтарч ажиллах явдлыг сайжруулах

*Нийт ELL сурагчдын эрэлт хэрэгцээ тэгш хангагдаж байх нөхцлийг хангах үүднээс хөтөлбөрийн арга хэлбэрийг сайжруулах,*

- (1) ELL сурагчдын хэрэгцээнд нийцүүлсэн цэцэрлэгээс өмнөх насны боловсролын үйлчилгээг нэвтрүүлэх
- (2) ELP ангиллын 5–р зэрэглэлд буй ELL сурагчдыг дэмжих, сурлагыг хянахад багш ажилчдын хариуцлага, оролцоог зөв хуваарилах
- (3) Сургалтын агуулгатай холбогдох Англи хэлний хичээлийг тухайн агуулгын дагуу зөв зохистой заах багш нарт тавих шалгуур, үзүүлэлтийг сайжруулах
- (4) ELL сурагчдад зориулж унших хичээлийг сургалтын агуулгатай холбох аргыг дахин сэргээж ашиглах
- (5) Дунд сургуульд суралцаж буй ELL сурагчид гүнзгийрүүлсэн сургалтуудад элсэн орох явдлыг дэмжсэн үйл ажиллагаа, бодлого гаргаж ажиллах

*ELL сурагчдад багшилж байгаа багш нарын ажлын байранд түшиглэсэн, байнгын мэргэжил дээшлүүлэх байдлыг хэлбэршүүлэх,*

- (1) ELL сурагчдад багшилж буй багш нарын мэргэжил дээшлүүлэлт тогмолжиж, улмаар зохих үр дүнд хүрэхэд түлхэц болж чадаж байгаа эсэхэд хяналт тавих,
- (2) Мэргэжил дээшлүүлэлтийн үр дүнгийн үнэлгээ, үүнд хяналт тавих хяналтын тогтолцоог сайжруулах.

*ELL сурагчидтай холбогдож гарч буй сургалтын болон үйл ажиллагааны холбогдолтой шийдвэр журмын чанарт нөлөөлөхүйц бодит мэдээллийн сангийн найдвартай үйл ажиллагааг нэмэгдүүлэх.*

- (1) Сурагчдын хамааралтай мэдээллийн сангийн үйл ажиллагааг тасралтгүй сайжруулах, ингэснээр багш, ажилчид ELL сурагчдын сургалттай хамааралтай шийдвэр гаргахдаа мэдээллийн сангийн мэдээллийг бүрэн ашигладаг болох буюу мэдээлэлд- түшиглэсэн шийдвэр гаргадаг болох.
- (2) ELL сурагчдын хувийн мэдээлэл, Англи хэлний мэдлэгийн түвшингийн талаар болон сурлагын явцын талаархи мэдээллийг хүртээмжтэй болгох.